



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

СБА-2022/110/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Баруун-Урт сум

2022 он

Тэргүүлэх аудитор: М.Нарантуяа

Утас: 70518369

Аудитын менежер: Г.Даваа

Утас: 70512123

Аудитор:

Утас: 70512127

Цахим хаяг: [narantuyam@audit.gov.mn](mailto:narantuyam@audit.gov.mn)

Цахим хаяг: [davaag@audit.gov.mn](mailto:davaag@audit.gov.mn)

А.Мөнхцэцэг

Цахим хаяг: [Munkhtsetsega@audit.gov.mn](mailto:Munkhtsetsega@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	6
3. Аудитын тайлан.....	7
3.1 Ерөнхий зүйл.....	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	8
3.4 Материаллаг байдал .....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	9
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	10
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	10
3.8 Аудитын гол асуудал .....	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	11
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
4.1 Зөвлөмж.....	11

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг  
Утас: 70518396, Факс: 70518396  
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № 77  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

СҮХБААТАР АЙМГИЙН БАРУУН-УРТ  
СУМЫН 10 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Х.БАЙГАЛЬМАА ТАНАА

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баруун-Урт сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баруун-Урт сумын 10 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА



## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>20,925,420.00</u></b>	<b><u>20,702,368.42</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	115,300.00	30,086.02
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	115,300.00	30,086.02
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	20,810,120.00	20,672,282.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	520,000.00	1,446,200.00
35130	Эм боох материал	520,000.00	1,446,200.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	20,290,120.00	19,226,082.40
35410	Бичиг хэргийн материал	94,000.00	531,250.00
35420	Аж ахуйн материал	00.00	152,390.00
35450	Барилгын засварын материал	790,000.00	00.00
35460	Хүнсний материал	925,800.00	215,922.40
35470	Бусад хангамжийн материал	18,480,320.00	18,326,520.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>485,548,793.22</u></b>	<b><u>471,003,335.10</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	485,548,793.22	471,003,335.10
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	468,556,793.22	454,011,335.10
39201	Барилга, байгууламж, орон сууц	472,894,955.11	472,894,955.11
39202	Хуримтлагдсан элэгдэл	-22,287,708.96	-33,431,563.44
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	32,959,293.00	36,319,293.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-25,727,873.65	-28,485,907.53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	36,781,893.00	36,781,893.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,088,765.28	-30,092,335.04
39217	Ном	25,000.00	25,000.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	16,992,000.00	16,992,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,992,000.00	16,992,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>506,474,213.22</u></b>	<b><u>491,705,703.52</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>506,474,213.22</u></b>	<b><u>491,705,703.52</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	506,474,213.22	491,705,703.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	21,240,000.00	21,240,000.00
51101	Өмч: - төрийн	21,240,000.00	21,240,000.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	483,808,203.11	469,039,693.41
51210	Өмнөх үеийн үр дүн	483,808,203.11	483,808,203.11
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-14,768,509.70
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,426,010.11	1,426,010.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>506,474,213.22</u></b>	<b><u>491,705,703.52</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>327,116,200.00</b>	<b>358,833,100.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>3,499,000.00</b>	<b>73,600.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	3,499,000.00	73,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,499,000.00	73,600.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	3,499,000.00	73,600.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>29,711,200.00</b>	<b>30,731,600.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,906,000.00	328,027,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>00.00</b>	<b>180,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	180,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	29,711,200.00	30,551,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,711,200.00	30,551,600.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>346,269,660.29</b>	<b>373,601,609.70</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>346,269,660.29</b>	<b>373,601,609.70</b>

**Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>334,539,758.18</b>	<b>343,532,611.89</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>225,878,162.50</b>	<b>237,972,280.74</b>
210101	Үндсэн цалин	145,634,749.35	157,048,241.31
210102	Нэмэгдэл	54,400,396.20	58,225,209.88
210104	Урамшуулал	25,843,016.95	22,698,829.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>28,362,170.39</b>	<b>29,260,543.89</b>
210201	Тэтгэврийн даатгал	19,106,442.51	20,244,836.85
210202	Тэтгэмжийн даатгал	2,333,954.40	2,298,762.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,866,983.55	1,663,350.08
210204	Ажилгүйдлийн даатгал	459,689.99	618,863.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,595,099.94	4,434,731.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>25,932,510.00</b>	<b>25,902,183.54</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,082,006.00	2,789,850.50
210302	Түлш, халаалт	20,971,004.00	18,972,333.04
210303	Цэвэр, бохир ус	2,879,500.00	4,140,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>5,354,570.00</b>	<b>7,450,740.00</b>
210401	Бичиг хэрэг	1,373,600.00	1,835,080.00
210402	Тээвэр, шатахуун	478,200.00	340,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	74,100.00	600,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,428,670.00	4,675,660.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>22,719,091.50</b>	<b>19,428,125.60</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,734,690.00	4,404,500.00
210502	Хоол, хүнс	17,969,401.50	15,023,625.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,015,000.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>1,810,120.00</b>	<b>4,936,180.00</b>
210604	Урсгал засвар	1,810,120.00	4,936,180.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>999,000.00</b>	<b>611,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	999,000.00	611,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,484,133.79</b>	<b>17,971,458.12</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	464,350.00	66,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	23,019,783.79	17,905,458.12
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,729,902.11</b>	<b>30,068,997.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>00.00</b>	<b>28,100,000.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	28,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>10,946,532.11</b>	<b>1,676,081.35</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,946,532.11	1,676,081.35
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>783,370.00</b>	<b>292,916.46</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	783,370.00	292,916.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-19,153,460.29</b>	<b>-14,768,509.70</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-19,153,460.29</b>	<b>-14,768,509.70</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,240,000.00	1,426,010.11	483,808,203.11	00.00	506,474,213.22
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	21,240,000.00	1,426,010.11	483,808,203.11	00.00	506,474,213.22
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-14,768,509.70	00.00	-14,768,509.70
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	21,240,000.00	1,426,010.11	469,039,693.41	00.00	491,705,703.52

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>323,617,200.00</b>	<b>358,759,500.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>323,617,200.00</b>	<b>358,759,500.00</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	293,906,000.00	328,027,900.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	180,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	180,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	29,711,200.00	30,551,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	29,711,200.00	30,551,600.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>323,617,200.00</b>	<b>355,399,500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>323,617,200.00</b>	<b>355,399,500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>311,887,297.89</b>	<b>325,330,502.19</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	225,878,162.50	236,965,147.92
210101	Үндсэн цалин	145,402,920.35	157,078,327.33
210102	Нэмэгдэл	54,400,396.20	57,187,991.04
210104	Урамшуулал	26,074,845.95	22,698,829.55
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,362,170.39	30,297,762.73
210201	Тэтгэврийн даатгал	19,106,442.51	21,282,055.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,333,954.40	2,298,762.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,866,983.55	1,838,850.08
210204	Ажилгүйдлийн даатгал	459,689.99	443,363.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,595,099.94	4,434,731.19
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	25,932,510.00	26,258,683.54
210301	Гэрэл, цахилгаан	2,082,006.00	2,789,850.50
210302	Түлш, халаалт	20,971,004.00	18,972,333.04
210303	Цэвэр, бохир ус	2,879,500.00	4,496,500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,344,670.00	2,520,150.00
210401	Бичиг хэрэг	91,500.00	334,200.00
210402	Тээвэр, шатахуун	478,200.00	240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	74,100.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	52,000.00	24,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,648,870.00	1,321,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	21,521,755.00	15,604,928.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,020,690.00	275,300.00
210502	Хоол, хүнс	17,888,325.00	14,199,768.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	612,740.00	1,129,860.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,995,320.00	2,720,000.00
210604	Урсгал засвар	2,995,320.00	2,720,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	980,800.00	7,582,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	980,800.00	7,582,450.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,871,910.00	3,381,380.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	00.00	893,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,871,910.00	2,488,380.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>11,729,902.11</b>	<b>30,068,997.81</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	28,100,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	28,100,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	10,946,532.11	1,676,081.35
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	10,946,532.11	1,676,081.35
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	783,370.00	292,916.46
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	783,370.00	292,916.46
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>3,360,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>00.00</b>	<b>3,360,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>3,360,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	3,360,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	00.00	3,360,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>00.00</b>	<b>-3,360,000.00</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	358,579,500.00	356,610,502.19
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	358,579,500.00	356,610,502.19
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	330,479,500.00	328,510,502.19
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	238,248,200.00	236,965,147.92
210101	Үндсэн цалин	166,764,500.00	157,078,327.33
210102	Нэмэгдэл	46,139,600.00	57,187,991.04
210104	Урамшуулал	25,344,100.00	22,698,829.55
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,520,900.00	30,297,762.73
210201	Тэтгэврийн даатгал	21,693,200.00	21,282,055.69
210202	Тэтгэмжийн даатгал	2,206,900.00	2,298,762.64
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,765,500.00	1,838,850.08
210204	Ажилгүйдлийн даатгал	441,400.00	443,363.13
210205	Эрүүл мэндийн даатгал	4,413,900.00	4,434,731.19
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	26,551,600.00	26,258,683.54
210301	Гэрэл, цахилгаан	2,284,800.00	2,789,850.50
210302	Түлш, халаалт	19,140,000.00	18,972,333.04
210303	Цэвэр, бохир ус	5,126,800.00	4,496,500.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,530,500.00	2,520,150.00
210401	Бичиг хэрэг	269,200.00	334,200.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00	240,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	603,500.00	600,000.00
210404	Ном, хэвлэл	62,100.00	24,450.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,345,700.00	1,321,500.00
2105	<b>Нормативт зардал</b>	15,454,900.00	15,424,928.00
210502	Хоол, хүнс	14,200,000.00	14,199,768.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,159,600.00	1,129,860.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	117,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	117,000.00	00.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	7,582,600.00	7,582,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,582,600.00	7,582,450.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3673800.00	3661380.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,780,800.00	2,768,380.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	358,579,500.00	356,610,502.19
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	328,027,900.00	326,351,818.65
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	328,027,900.00	326,351,818.65
1320	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	30,551,600.00	30,258,683.54
132001	Орон нутгийн төсвөөс	30,551,600.00	30,258,683.54

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
I	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>180,000.00</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>180,000.00</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	180,000.00
2105	<b>Нормативт зардал</b>	180,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	180,000.00
II	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	180000.00
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	180,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	180,000.00
IV	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг 2022 оны 1 дүгээр сарын 15-наас 2022 оны 2 дугаар сарын 25-ны хооронд Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Мөнхцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Тус байгууллага 2021-2022 оны хичээлийн жилд "Хүүхдээ дээдлэн багшаа хөгжүүлж, сургалтын таатай орчныг бүрдүүлэн эцэг эх олон нийтийн оролцоог сайжруулж СӨБ-ыг чанартай эзэмшүүлэх зорилго дэвшүүлж уг зорилгыг хангахаар СӨБ олгох хувилбарт сургалтад хамран сургалтыг нэмэгдүүлэх, сургалтын чанарыг ахиулах зорилтыг тодорхойлсон байна.

Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд оршино.

Баруун-Урт сумын 10-р цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол олгох үндсэн зорилт чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг Баруун-Урт сумын ТТЗ-ийн харьяа байгууллага юм.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн нь хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд нийт ажил гүйлгээний ихэнх хувийг зардлын гүйлгээ эзэлдэг бөгөөд төсвийн санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байдлыг татвар төлөгч, иргэд илүү анхаардаг учир материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 346.3 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 5.2 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 3.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 14.8 сая төгрөг буюу 2.9 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материалын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая.төг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.1	0.03	-0.07
Бараа материал	20.8	20.7	-0.1
Үндсэн хөрөнгө	485.5	471.0	-14.5
<b>Нийт хөрөнгө</b>	<b>506.5</b>	<b>491.7</b>	<b>-14.8</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	<b>506.5</b>	<b>491.7</b>	<b>-14.8</b>
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>506.5</b>	<b>491.7</b>	<b>-14.8</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 20.7 сая төгрөг болж 0.1 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 471.7 сая төгрөг болж 14.5 сая төгрөгөөр буурсан байна. Тайлант онд төсвийн хөрөнгөөр 3.4 сая төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авч, 17.9 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан нь нөлөөлжээ.

Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 31.7 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт байна.

Нийт зардал өмнөх оноос 27.3 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс болон нэмэгдэл, ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөн нөлөөлсөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 74.3 сая төгрөгөөр бууруулж 349.3 сая төгрөгөөр баталсан байна. Харин төсвийн тодотголоор тус байгууллагын төсөв 20.1 сая төгрөгөөр нэмэгджээ.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 358.5 сая төгрөгийг улсын төсвөөс баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 328.0 сая, орон нутгийн төсвөөс 30.5 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 356.6 сая төгрөг зарцуулж, 1.9 сая төгрөгийн төсвийн үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд Ковид19 цар тахлын өвчлөлтэй холбогдуулан дээд газраас /яамнаас/ 0.2 сая төгрөгийн эм бэлдмэлийн зардлыг нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Баруун-Урт сумын 10-р цэцэрлэг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 82 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжилт нь 85.0 хувьтай үнэлэгдсэн байна.

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн үйл ажиллагаа, тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үйл явдал болон засаглах эрх бүхий этгээдүүдийн түвшин дэх харилцаатай холбоотой санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудал байхгүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах асуудал гараагүй.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2, хугацаандаа оруулсан 126 мэдээлэл, 257.6 сая төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгт "Итгэл" үзүүлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэгийн тайлант оны үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл, ажил гүйлгээ болон санхүүгийн тайланг тасалбар болгож гаргасан өдрөөс хойших үйл явдлыг шинжилж үзэхэд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар шилэн данс, үндсэн хөрөнгийн зардалтай холбоотой нийт 3 зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

### **4.1 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 47 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байгаа зөрчил нь УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлд тусгасан “Хөрөнгийн үлдэх өртөг ба ашиглалтын хугацааг наад зах нь санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үзэх ба хэрэв хүлээлт нь өмнөх тооцооллоос өөр байвал уг өөрчлөлтийг УСНББОУС 3 тооцооллын өөрчлөлтийн дагуу тайлагнана” заалттай нийцэхгүй байна.

**1.2. Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож, УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах.

**2. Шилэн данстай холбоотой**

**2.1 Илрүүлэлт:**

Шилэн дансны цахим мэдээлэлд 257.6 сая төгрөгийн 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дугаар зүйлийн 4.1.3-т заасан “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” заалт, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”, “иж бүрэн байх”, “үнэн зөв байдал” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:**

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах

**3. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал**

**3.1 Илрүүлэлт:**

Үндсэн хөрөнгө худалдан авахдаа хэрэгцээ шаардлагаа бодитой тодорхойлсон эсэх нь тодорхойгүй, өмч хамгаалах зөвлөлийн шийдвэр болон ИТХ, орон нутгийн өмчийн албаны зөвшөөрөлгүйгээр хөрөнгө худалдан авсан.

**3.2 Өгсөн зөвлөмж:**

Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сэлбэг хэрэгсэл, эд анги солиход тавих хяналтыг сайжруулах, шаардлагатай хөрөнгийг холбогдох газрын шийдвэрийн дагуу бэлтгэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		/сая төгрөгөөр/							
				Үүнээс							
		Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Баруун-Урт сумын аравдугаар цэцэрлэг	3	3.4	-	-	-	-	-	-	3	3.4